

“АКСИС КАПИТАЛ ББСБ” ХХК-ИЙН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

“Аксис Капитал ББСБ” ХХК-ийн 2025 оны Үйл ажиллагааны нэгдсэн тайланг хүргэж байна. Хэдийгээр тухайн жилд зах зээлийн нөхцөл байдал таагүй байсан ч манай компани Бизнес төлөвлөгөөнийхөө дагуу тавьсан зорилго, зорилтуудаа хангахын тулд нөөц бололцоогоо дайчлан ажиллалаа.

№	Үндсэн ажиллагааны хүрээнд:
1	2025 оны 1-р сард компанийн 2024 оны Санхүүгийн тайлан, гүйцэтгэлийг хэлэлцэж, нийт ажилтнуудын хэмжээнд үр дүнгийн хурал зохион байгуулсан.
2	Компанийн Хувьцаа эзэмшигчидийн хурлыг зохион байгуулж ТУЗ-ийн гишүүдийг томилон ТУЗ байгуулсан.
3	Зөв засаглалын зарчмын дагуу ТУЗ-ийн дэргэдэх хороодыг байгуулж, үйл ажиллагааг идэвхжүүлсэн.
4	Компанийн эрхэм зорилго, Үнэт зүйлс, Брэндбүүкийг зорилго, зорилтуудтайгаа уялдуулан шинэчилсэн.
5	СЗХ-оос шинэчлэгдэн батлагдсан Компанийн засаглалын кодексын дагуу шаардлагатай бүх бодлого, журмуудыг боловсруулж үйл ажилагаандаа мөрдөж эхэлсэн.
6	Компанийн хүний нөөцийн төлөвлөлтийн хүрээнд 12 ажилтан шинээр нэмж, 6 ажилтан албан тушаал дэвшиж, үндсэн ажилтны тоо 22 болсон.
7	Өөрийн хөрөнгөө нэмэгдүүлж зохицуулалтын байгууллагад бүртгүүлэн ажилласан.
8	Баянгол, Хан-Уул салбар нэгж байгуулах зөвшөөрлийг СЗХ-оос авч үйл ажиллагааг эхлүүлснээр нийт 5 салбартай болсон.
9	СЗХ-оос Итгэлцэл үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрлийг нэмж авсан.
10	2025 оны 4-р сард Биржийн бус захаас татан төвлөрүүлсэн 4,7 тэрбум төгрөгийн дүнтэй "АКСИС бонд 1"- бондыг Биржийн бус зах дээр амжилттай гаргасан.
11	Тухайн жилд санхүү, мөнгөн урсгалын зөв төлөвлөлтийг хийж ажилласнаар Санхүүгийн байгууллагууд болон хөрөнгө оруулагчид, Итгэлцэл байршуулсан харилцагчдын өмнө хүлээсэн үүргээ цаг тухайд нь бүрэн биелүүлэн ажиллалаа.
12	Компанийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд “Сэрэлт Дөл Аудит” ХХК-аар хөндлөнгийн аудит хийлгэж, баталгаажуулан Банк бус санхүүгийн байгууллагуудын холбооны цахим хуудас болон компанийн өөрийн http://www.axiscapital.mn вэбсайтаар дамжуулан олон нийтэд түгээсэн.
Эрсдэлийн удирдлага:	
13	Эдийн засаг, зах зээлийн нөхцөл байдал, Төрийн зохицуулагч байгууллагуудын шийдвэр, чиглэлийг анхааралтай ажиглаж, шаардлагатай арга хэмжээг шуурхай авч ажилласан.

	Бүтээгдэхүүн, Санхүү, Комплаенс, Үйл ажиллагааны эрсдэл тэдгээртэй холбоотой процессыг дахин үнэлж, нэгжүүд хоорондын уялдаа холбоог сайжруулсан.
14	ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн хороо нь эрсдэлийн төрөл, хэмжээ, хязгаарыг тодорхойлох, хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэн нийт 2 удаа, 100 хувийн ирцтэйгээр хуралдаж, холбогдох шийдвэрүүдийг гарган ажилласан. Үүнд: Комплаенсийн эрсдэлийн үнэлгээнд дүгнэлт гаргаж, эрсдлийн тайланг хэлэлцэн, эрсдлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлж ажилласан.
15	ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо нь тайлант хугацаанд нийт 2 удаа, 100 хувийн ирцтэйгээр хуралдсан. Хороо нь Дотоод аудитын хэлтсийн төлөвлөгөөт ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, шууд удирдлагаар хангаж ажилласан.
16	Санхүүгийн зохицуулах хорооноос мөрдүүлдэг “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаа”-ны тоон болон чанарын шаардлагыг хангахад чиглэсэн сургалт, судалгааг хийж ажилласан.
17	Мэдээллийн аюулгүй байдлын хэвийн үйл ажиллагааг хангах, нууцлалыг хамгаалах, мэдээллийн системийн хяналтын тогтолцоог сайжруулах зорилгоор тогтмол хяналт тавьж, сайжруулалт хийн ажилласан байна.
	Сургалт, хөгжүүлэлт чиглэлээр:
18	Ажилтнуудыг ажил мэргэжлийн хүрээнд чадавхижуулах зорилгоор шаардлагатай чиглэл бүрээр байгууллагын дотоод сургалтанд 5 удаа, гадаад сургалтанд 1 удаа тус тус хамруулсан. Тодруулбал Монгол банк, СЗХорооноос зохион байгуулсан “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой байж болзошгүй сэжигтэй гүйлгээний шинж тэмдгүүд” хэлэлцүүлэг, Эргэцүүлэх сэтгэлгээ зэрэг сургалтуудад хамруулсан.
	Хамтын ажиллагааны хүрээнд:
19	Үндсэн үйл ажиллагааны бизнесийн гол бүтээгдэхүүн болох автомашины барьцаалсан зээлийн хувьд жолоочийн хариуцлагын болон тээврийн хэрэгслийн даатгалын үйлчилгээ үзүүлэгчид болох МИГ даатгал, Хаан Даатгал ХХК-тай хамтран ажилласан.
20	Биржийн бус зах зээлд бонд гаргахтай холбоотой үйл ажиллагааны хүрээнд Мандал Капитал Маркетс ҮЦК ХХК-тай хамтран ажиллав.
21	Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд болох Бүрэнскор ХХК болон Титан Си Ар Эй ХХК-тай хамтран ажиллав Мөн хөрөнгө оруулагч, зээлдэгч, автомашин худалдаа эрхлэгчид, бусад оролцогч талуудтай түргэн шуурхай, мэргэжлийн, хариуцлагатай хамтран ажиллах зарчим баримтлан ажиллав.
	Нийгмийн хариуцлагын хүрээнд:
22	Компани зээлийн бодлогоороо байгаль орчинд ээлтэй байх зарчмыг баримталж зээл хүсэгчийн эрхэлж буй бизнес, зээлийн хөрөнгөөр

	санхүүжүүлэх үйл ажиллагаа нь нийгэм, бие хүн, байгаль орчинд хор нөлөөгүй байх шаардлагыг хангасан ногоон зээлийг олгож, тайланг зохицуулагч байгууллагад мэдээлэн ажиллаж байна
23	Нийт ажилтнуудын эрүүл мэнд, цалин урамшууллыг сайжруулах зорилгоор холбогдох бодлого, журамд буцалтгүй тусламж, хөнгөлөлт урамшууллын системийг тусган, түүнийг хэрэгжүүлсэн.
24	Эх үрсийн баярыг угтан ажилтнуудынхаа хүүхдүүдийн дунд баярын арга хэмжээ зохион байгуулж, идэвхжүүлэлт хийсэн.
25	Ажилтнууд болон тэдгээрийн гэр бүлийн гишүүдийн эрүүл мэнд, хөдөлгөөнийг дэмжих зорилгоор спортоор хичээллэхэд дэмжлэг үзүүлж, спорт клубын төлбөрийн хөнгөлөлт үзүүлж эхэлсэн.
26	Нийслэлийн хамгийн их утаатай бүсэд орших Сонгинохайрхан дүүргийн ерөнхий боловсролын 9 болон 42-р сургууль Чингэлтэй дүүргийн гэр хороолол дунд орших Ерөнхий боловсролын 17, 37, 61-р сургууль, нийт 5 сургуульд 110 ширхэг анги танхимын орчны агаар сайжруулах цэвэршүүлэгч төхөөрөмж хандивласан.
	Эрсдэлийн бодлого:
27	Эдийн засаг, зах зээлийн нөхцөл байдал, төрийн зохицуулагч байгууллагуудын бодлого шийдвэрийг анхааралтай ажиглаж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг түргэн шуурхай авч ажиллав. - Өр орлогын харьцааг 40/60 хэмжээнд барьж ажиллав. - Зээл, барьцаа хөрөнгийн үнэлгээний харьцааг нэмэгдүүлж ажиллав. - Улирлын чанартай үйл ажиллагаа эрхлэгч зээлдэгчдэд зээлийн хязгаарлалт тогтоон ажиллав.

Санхүүгийн байдлын хувьд:

28. 2024 болон 2025 оны санхүүгийн тайлангийн гол үзүүлэлтүүд дараах байдалтай байна. Үүнд:

	<u>2024 он</u>	<u>2025 он</u>	<u>өөрчлөлт</u>
ХӨРӨНГӨ			
Мөнгө ба түүнтэй адилтгах зүйлс	764,171	2,229,795	191.8%
Зээл	17,334,913	29,705,472	71.4%
Үндсэн хөрөнгө	207,019	388,488	87.7%
Хуримтлагдсан хүүгийн авлага	275,820	767,411	178.2%
Бусад актив	10,267	13,386	30.4%
ХӨРӨНГИЙН ДҮН	18,592,190	33,104,552	78.1%
ӨР ТӨЛБӨР			
Итгэлцлийн үйлчилгээний өглөг	-	8,284,907	
Дотоод зээл	6,500,000	-	-100.0%
Бусад өглөг	267,465	692,727	159.0%
Өрийн бичиг	-	4,700,000	
Хуримтлагдсан хүүгийн өглөг	-	-	
ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	6,767,465	13,677,634	102.1%
ӨӨРИЙН ХӨРӨНГӨ			
Хувьцаат капитал	10,000,000	13,000,000	30.0%
Тайлангийн үеийн ашиг	1,824,728	4,602,192	152.2%
Өмнөх үеийн ашиг	-	1,824,728	
ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	11,824,728	19,426,920	64.3%
ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	18,592,193	33,104,554	78.1%

29. 2025 оны жилийн эцсийн тайлангийн үзүүлэлтээр Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн ханган ажилласан.

ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ				
АКСИС КАПИТАЛ ББСБ				
БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА				
31/12/2025				
Д/д	ЗОХИСТОЙ ҮЗҮҮЛЭЛТ	БАЙВАЛ ЗОХИХ	ТАЙЛАНГААР	ХАНГАСАН ЭСЭХ
А. ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ХҮРЭЛЦЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТ				
1	НЭГДҮГЭЭР ЗЭРЭГЛЭЛИЙН ӨӨРИЙН ХӨРӨНГӨ, ЭРСДЭЛЭЭР ЖИГНЭСЭН НИЙТ АКТИВЫН ХАРЬЦАА	10%-аас доошгүй	57.1%	Хангасан
2	ӨӨРИЙН ХӨРӨНГӨ, ЭРСДЭЛЭЭР ЖИГНЭСЭН НИЙТ АКТИВЫН ХАРЬЦАА	20%-аас доошгүй	57.1%	Хангасан
3	ӨӨРИЙН ХӨРӨНГӨ, НИЙТ АКТИВЫН ХАРЬЦАА:	30%-аас доошгүй	58.7%	Хангасан
Б. ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАРЫН ХАРЬЦАА				
4	ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАРЫН ХАРЬЦАА	8%-аас дээш	24.8%	Хангасан
В. АКТИВ ХӨРӨНГИЙН ТӨВЛӨРЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ				
5	ХӨРӨНГӨ /АКТИВ/-ИЙН ЭРСДЭЛИЙН САНГИЙН ХҮРЭЛЦЭЭ (+нлүү, - дууу)	251,193,500.8	251,193,500.8	0.0
6	НЭГ ЗЭЭЛДЭГЧ БОЛОН ХОЛБОГДОХ ЭТГЭЭДЭД ОЛГОСОН ЗЭЭЛ, ЗЭЭЛТЭЙ АДИЛТГАН ТООЦОХ БУСАД АКТИВ ХӨРӨНГӨ, ТӨЛБӨРИЙН БАТАЛГААНЫ ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	30%-аас хэтрэхгүй	2.6%	Хангасан
7	ББСБ-ААС ГАРГАСАН ТӨЛБӨРИЙН БАТАЛГААНЫ ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	70%-аас хэтрэхгүй	0.0%	-
8	ББСБ-ЫН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ, ТУЗ, ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ АЖИЛТАН ХОЛБОГДОХ ЭТГЭЭДЭД ОЛГОСОН ЗЭЭЛ, ЗЭЭЛТЭЙ АДИЛТГАН ТООЦОХ БУСАД АКТИВ ХӨРӨНГӨ, ТӨЛБӨРИЙН БАТАЛГААНЫ НИЙЛБЭР ДҮНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	25%-аас хэтрэхгүй	1.4%	Хангасан
9	ББСБ-ЫН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ, ТУЗ, ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ АЖИЛТАН, ХОЛБОГДОХ НЭГ ЭТГЭЭДЭД ОЛГОСОН ЗЭЭЛ, ЗЭЭЛТЭЙ АДИЛТГАН ТООЦОХ БУСАД АКТИВ ХӨРӨНГӨ, ТӨЛБӨРИЙН БАТАЛГААНЫ ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	10%-аас хэтрэхгүй	0.2%	Хангасан
10	ҮНЭТ ЦААСНЫ ЭЗЭМШИЛ ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	50%-аас хэтрэхгүй	0.0%	-
	КОМПАНИЙН ХУВЬЦАА, ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	20%-аас хэтрэхгүй	0.0%	-
	МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН "Г", "П" АНГИЛАЛЫН НЭГ КОМПАНИЙН ГАРГАСАН ХУВЬЦААНААС ХУДАЛДАЖ АВАХ ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	20%-аас хэтрэхгүй	0.0%	-
	КОМПАНИЙН ӨРИЙН БИЧИГ ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	20%-аас хэтрэхгүй	0.0%	-
	БУСАД ҮНЭТ ЦААС, ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	10%-аас хэтрэхгүй	0.0%	-
Г. ГАДААД ВАЛЮТЫН ХАНШИЙН ЭРСДЭЛ				
11	ГАДААД АКТИВ, ПАССИВЫН ЗӨРҮҮ ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	(+/-40%)	0.1%	Хангасан
Д. БУСДААС ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД				
12	ИТГЭЛЦЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨГЛӨГ ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	60%-аас хэтрэхгүй	42.6%	Хангасан
13	ИТГЭЛЦЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭГЭЭР ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ЭХ ҮҮСВЭРИЙН НӨӨЦ САН	138,065,767.0 828,490,725.0	150,000,000.0	Хангасан
18	ӨРИЙН БИЧГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	30%-аас хэтрэхгүй	24.2%	Хангасан
Е. ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ				
17	ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	15%-аас хэтрэхгүй	1.1%	Хангасан
Ж. ӨГӨӨЖ				
19	ХӨРӨНГӨ /АКТИВ/-ИЙН ӨГӨӨЖ			17.8%
20	ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ӨГӨӨЖ			29.5%

АКСИС КАПИТАЛ ББСБ ХХК

2026 оны 3 сарын 13 өдөр